



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 71105

Улаанбаатар хот

Морин-Уул дахь Допплерийн радарын станцын
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны төвийн бүсийн нутаг дэвсгэрийг цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай локаторын мэдээллээр хангах үүрэг бүхий тус газрын харъяа Нислэгийн цаг уурын төвийн Морин-Уул дахь цаг уурын Допплерийн радарын станцын клистроны ашиглалтын хугацаа дуусч байгаа, 2018 оны улсын төсвийн төсөлд сэлбэг худалдан авах зардал тусгагдаагүй байдлыг харгалзан тус станцын үйл ажиллагааг 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл түр хугацаагаар зогсоосугай.

2. Допплерийн радарын станцыг цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед саадгүй ажиллуулах, бэлэн байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч, сул зогсолтын хугацаанд радарын инженерүүдийн ээлжийн амралтыг эдлүүлэх, ажил үүргийн хуваарьт нь түр хугацаагаар өөрчлөлт оруулж, өмнөх жилүүдэд ажиглагдсан, доплерийн радаргаар илрүүлсэн цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн талаар судалгаа хийж, цахим мэдээллийн сан үүсгэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Пунцагдорж, Нислэгийн цаг уурын төвийн дарга Б.Баньдсүрэн нарт үүрэг болгосугай.

ДАРГА  С.ЭНХТҮВШИН